## УВС АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

# САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сангийн 2025 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

**Аудитын код:** УВА-2026/002/НА-СТА-ЗГТС


| | |
|---|---|
| Цахим хуудас: www.audit.mn<br>Улаангом хот<br>2026 он | Увс аймаг дахь Төрийн аудитын газар<br>Дарга, тэргүүлэх аудитор: М.Батсуурь<br>Утас: 70453317, Цахим хаяг: BatsuuriM@audit.gov.mn<br><br>Аудитын менежер: М.Бат-Амгалан<br>Утас: 70453799, Цахим хаяг: Bat-Amgalanm@audit.gov.mn<br><br>Аудитор: Л.Шагдарсүрэн<br>Утас: 70453721, Цахим хаяг: Shagdarsurenl@audit.gov.mn |


Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

Агуулга


**1.ХАРААТ БУС АУДИТОРЫН ДҮГНЭЛТ** ........ 3-4

**2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ** ........ 5

2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан ........ 5

2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан ........ 5-6

2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан ........ 6-8

2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн ........ 8

2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан ........ 9-10

2.6 Аудит хийсэн нэмэлт санхүүжилтийн тайлан ........ 11

**3. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА** ........ **12**

3.1 Байгууллага, түүний үйл ажиллагаа ........ 12

3.2 Байгууллагын гадаад, дотоод орчин ........ 12

3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал ........ 13

3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого, толилуулгад гарсан өөрчлөлтүүд ........ 13

3.5 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв ........ 13

3.5.1 Төсвийн төлөвлөлт ........ 14

3.5.2 Төсвийн гүйцэтгэл ........ 14

3.5.3 Нэмэлт төсөв ........ 15

**4. АУДИТЫН ТАЙЛАН** ........ **16**

4.1 Ерөнхий зүйл ........ 16

4.2 Материаллаг байдал ........ 16

4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт ........ 16

4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал ........ 16

4.4.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт ........ 16

4.4.2 Бусад хууль тогтоомжийн хүрээнд ........ 16

4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт ........ 16

4.5.1 Завсрын аудитын талаар ........ 16

4.5.2 Өмнөх аудитын мөрөөр авч хэрэгжүүлсэн арга хэмжээний үр дүн ........ 16

4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал ........ 17

**6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ** ........ **18**


**Товчилсон үгийн жагсаалт**

| | |
|---|---|
| УСНББОУС | Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт |
| АДБОУС | Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт |

УВС АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР
213400, Увс аймаг, Улаангом сум,
Ө.Бадрахын гудамж
Утас: 70-45-33-17, Факс: (976)70-45-33-17,
E-mail: uvs@audit.gov.mn

2026.03.12 № УВД-2026/002/НА-СТД-3ГТС
танай ______________ -ны № ________________ -т

ХӨДӨЛМӨР, ХАЛАМЖИЙН
ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ГАЗРЫН ДАРГА
Д.БАЯРМАА ТАНАА

**Өөрчлөлтгүй дүгнэлт**

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.2-д заасны дагуу Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сангийн 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сангийн 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

**Дүгнэлтийн үндэслэл**

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

**Асуудлыг онцолсон хэсэг**

АДБОУС 2706.7-д тодорхойлсноор асуудлыг онцолсон хэсэгт санхүүгийн тайлангийн тухай хэрэглэгчдийн ойлголтыг бүрдүүлэхэд ач холбогдолтой, санхүүгийн тайланд толилуулсан, тодруулсан мэдээлэл байхгүй болно.

**Аудитын гол асуудал**

АДБОУС 2701.8-д тодорхойлсон тайлант үеийн санхүүгийн тайлангийн аудитад үлэмж нөлөө үзүүлэх ажил гүйлгээ байхгүй болно.

**Бусад асуудлын хэсэг**

Тайлант үеийн санхүүгийн тайлангийн аудитад санхүүгийн тайлангийн тодруулга толилуулгад тусгаагүй, аудитын хамрах хүрээний хязгаарлалтын улмаас аудитын хангалттай, зохистой нотолгоог олж авах боломжгүй асуудал гараагүй болно.

**Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага**

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

8525050686

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

**Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага**

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР М.БАТСУУРЬ

9065555 1525010041

## 2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ

### 2.1. Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

| Код | Үзүүлэлт | Эхний үлдэгдэл | Эцсийн үлдэгдэл |
|---|---|---|---|
| **1** | **ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН (I)** | **4,744,386,409.5** | **4,369,638,291.5** |
| **33** | **АВЛАГА** | **4,744,386,409.5** | **4,369,638,291.5** |
| 33700 | Хөтөлбөртэй холбоотой авлага | 4,744,206,409.5 | 4,369,638,291.5 |
| 33703 | Хувиараа хөдөлмөр эрхлэгч, нөхөрлөл, хоршоо байгуулах иргэнийг дэмжих | 2,041,743,506.5 | 1,934,510,863.5 |
| 33705 | Хөгжлийн бэрхшээлтэй иргэний хөдөлмөр эрхлэлтийг дэмжих | 302,396,503.00 | 268,310,303.00 |
| 33706 | Малчдын хөдөлмөр эрхлэлтийг дэмжих | 1,700,448,900.00 | 1,484,058,625.00 |
| 33707 | Засгийн газар, ХЭҮЗ бусад шийдвэрээр тодорхойлсон хөтөлбөр төслийн санхүүжилт | | 80,000.00 |
| 33717 | Ахмад мэргэжилтний зөвлөх үйлчилгээ | 645,469,500.00 | 644,967,500.00 |
| 33718 | Залуучуудын хөдөлмөр эрхлэлт, гарааны бизнесийг дэмжих | 50,548,000.00 | 37,531,000.00 |
| 33730 | Эмэгтэйчүүдийн хөдөлмөр эрхлэлтийг дэмжих хөтөлбөр | 3,600,000.00 | |
| 33300 | Татаас, санхүүжилтийн авлага | 180,000.00 | 180,000.00 |
| 2 | ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН (II) | - | - |
| **3** | **НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН (III=I+II)** | **4,744,386,409.5** | **4,369,638,291.5** |
| **4** | **НИЙТ ӨР ТӨЛБӨР (IV)** | **180,000.00** | **68,011,224.00** |
| **41** | **БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР** | **180,000.00** | **68,011,224.00** |
| 41700 | Хөтөлбөртэй холбоотой өглөг | 180,000.00 | 68,011,224.00 |
| 41701 | Ажил мэргэжлийн чиг баримжаа олгох, зөвлөгөө өгөх | | 8,254,224.00 |
| 41702 | Ажилд зуучлах | | 1,200,000.00 |
| 41705 | Хөгжлийн бэрхшээлтэй иргэний хөдөлмөр эрхлэлтийг дэмжих | | 35,000,000.00 |
| 41710 | Сурталчилгаа олон нийтийн арга хэмжээ зохион байгуулах | | 880,000.00 |
| 41713 | Хөтөлбөр төслийн хяналт үнэлгээ | | 1,425,000.00 |
| 41716 | Нийтийг хамарсан ажил | 180,000.00 | 180,000.00 |
| 41717 | Ахмад мэргэжилтний зөвлөх үйлчилгээ | | 19,440,000.00 |
| 41728 | Хүүхэд хамгаалагч төсөлтэй холбоотой өглөг | | 1,632,000.00 |
| **5** | **ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН (V)** | **4,744,206,409.5** | **4,301,627,067.5** |
| **51** | **Засгийн газрын хувь оролцоо** | **4,744,206,409.5** | **4,301,627,067.5** |
| 51200 | Хуримтлагдсан үр дүн | 4,744,206,409.5 | 4,301,627,067.5 |
| 51210 | Өмнөх үеийн үр дүн | 4,216,443,897.00 | 4,744,206,409.5 |
| 51220 | Тайлант үеийн үр дүн | 527,762,512.5 | -442,579,342.00 |
| **6** | **ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН (VI=IV+V)** | **4,744,386,409.5** | **4,369,638,291.50** |

## 2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

| Код | Үзүүлэлт | Өмнөх жилийн дүн | Тайлант жилийн дүн |
|---|---|---|---|
| **1** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)** | **2,381,853,500.00** | **1,047,831,230.00** |
| **12** | **ТАТВАРЫН БУС ОРЛОГО** | **2,380,053,500.00** | **1,047,831,230.00** |
| 1200 | Өмчийн орлого | 2,380,053,500.00 | 1,047,831,230.00 |
| 120004 | Төсөв байгууллагын өөрийн орлого | 2,380,053,500.00 | 1,047,831,230.00 |
| 1200041 | Үндсэн үйл ажиллагааны орлого | 917,515,000.00 | 530,665,000.00 |
| 1200042 | Туслах үйл ажиллагааны орлого | 2,820,000.00 | 51,835,430.00 |
| 1200043 | Урьд оны үлдэгдэлээс санхүүжих | 1,459,718,500.00 | 465,330,800.00 |
| 13 | ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО | 1,800,000.00 | |
| 1311 | Нэмэлт санхүүжилтийн орлого | 1,800,000.00 | |
| 131104 | Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан х | 1,800,000.00 | |
| **2** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН (II)** | **1,854,090,987.5** | **1,490,410,572.00** |
| **21** | **УРСГАЛ ЗАРДАЛ** | **1,854,090,987.5** | **1,490,410,572.00** |
| 210 | БАРАА, ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ | 57,309,630.00 | 48,646,719.00 |
| 2108 | Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж | 57,309,630.00 | 48,646,719.00 |
| 210801 | Бусдаар гүйцэтгүүлсэн нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж | 57,309,630.00 | 48,646,719.00 |
| 213 | УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ | 1,796,781,357.50 | 1,441,763,853.00 |
| 2133 | Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг | 152,711,937.00 | |
| 213303 | Төвлөрүүлэх шилжүүлэг | 152,711,937.00 | |
| 2134 | Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт | 2,640,000.00 | |
| 213403 | Төвлөрүүлэх шилжүүлэг | 2,640,000.00 | |
| 2135 | Төсвийн захирагчдаас олгосон санхүүжилт, шилжүүлэг | 1,126,237,487.50 | 1,076,501,481.00 |
| 213503 | Төвлөрүүлэх шилжүүлэг | 1,126,237,487.50 | 1,076,501,481.00 |
| 2132 | Бусад урсгал шилжүүлэг | 515,191,933.00 | 365,262,372.00 |
| 213205 | Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал | 515,191,933.00 | 365,262,372.00 |
| **3** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (III=I-II)** | **527,762,512.50** | **-442,579,342.00** |
| **4** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ОРЛОГЫН ДҮН (IV)** | **-** | **-** |
| **5** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН (V)** | **-** | **-** |
| **6** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ НИЙТ ҮР ДҮН (VI=III+IV-V)** | **527,762,512.50** | **-442,579,342.00** |

## 2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

| Код | Үзүүлэлт | Өмнөх жилийн дүн | Тайлант жилийн дүн |
|---|---|---|---|
| 1 | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (I)** | **2,381,853,500.00** | **1,047,831,230.00** |
| 12 | **ТАТВАРЫН БУС ОРЛОГО** | **2,380,053,500.00** | **1,047,831,230.00** |
| 1200 | Өмчийн орлого | 2,380,053,500.00 | 1,047,831,230.00 |
| 120004 | Төсөв байгууллагын өөрийн орлого | 2,380,053,500.00 | 1,047,831,230.00 |
| 1200041 | Үндсэн үйл ажиллагааны орлого | 917,515,000.00 | 530,665,000.00 |
| 1200042 | Туслах үйл ажиллагааны орлого | 2,820,000.00 | 51,835,430.00 |
| 1200043 | Урьд оны үлдэгдэлээс санхүүжих | 1,459,718,500.00 | 465,330,800.00 |
| 13 | **ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО** | **1,800,000.00** | |
| 1311 | Нэмэлт санхүүжилтийн орлого | 1,800,000.00 | |
| 131104 | Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан х | 1,800,000.00 | |
| 2 | **НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (II)** | **3,302,662,327.50** | **2,590,159,348.00** |
| 21 | **УРСГАЛ ЗАРДАЛ** | **3,302,662,327.50** | **2,590,159,348.00** |
| 210 | БАРАА, ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ | 57,309,630.00 | 46,621,719.00 |
| 2108 | Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж | 57,309,630.00 | 46,621,719.00 |
| 210801 | Бусдаар гүйцэтгүүлсэн нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж | 57,309,630.00 | 46,621,719.00 |
| 213 | УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ | 3,245,352,697.50 | 2,543,537,629.00 |
| 2133 | Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг | 152,711,937.00 | |
| 213303 | Төвлөрүүлэх шилжүүлэг | 152,711,937.00 | |
| 2134 | Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт | 2,640,000.00 | |
| 213403 | Төвлөрүүлэх шилжүүлэг | 2,640,000.00 | |
| 2135 | Төсвийн захирагчдаас олгосон санхүүжилт, шилжүүлэг | 920,808,827.50 | 1,076,501,481.00 |
| 213503 | Төвлөрүүлэх шилжүүлэг | 920,808,827.50 | 1,076,501,481.00 |
| 2132 | Бусад урсгал шилжүүлэг | 2,169,191,933.00 | 1,467,036,148.00 |
| 213205 | Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал | 2,169,191,933.00 | 1,467,036,148.00 |
| 3 | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (III=I-II)** | **-920,808,827.50** | **-1,542,328,118.00** |
| 4 | **ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (IV)** | - | - |
| 5 | **ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (V)** | - | - |
| 6 | **ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (VI=IV-V)** | - | - |
| 9 | **САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН** | **920,808,827.50** | **1,542,328,118.00** |
| 145 | Бусад орлого (олз) | 920,808,827.50 | 1,542,328,118.00 |
| 145004 | Дотоод эх үүсвэрээс олгосон зээлээс эргэж төлөгдөх | 920,808,827.50 | 1,542,328,118.00 |
| 10 | САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН | - | - |
| 7 | **САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (VII)** | **920,808,827.50** | **1,542,328,118.00** |
| 8 | НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (VIII=III+VI+VII) | - | - |
| 14 | Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл | - | - |
| 15 | Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл | - | - |

## 2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

| Код | Үзүүлэлт | Засгийн газрын хөрөнгө оруулсан капитал | Дахин үнэлгээний нөөц | Хуримтлагдсан үр дүн | Бусад | НИЙТ ДҮН |
|---|---|---|---|---|---|---|
| 1 | 2025 оны 1-р сарын 1-ний үлдэгдэл | - | - | - | - | - |
| 2 | Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт | - | - | - | - | - |
| 3 | Дахин илэрхийлсэн үлдэгдэл | - | - | - | - | - |
| 4 | Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт бууралт | - | - | - | - | - |
| 5 | Үндсэн хөрөнгийн өсөлт бууралт | - | - | - | - | - |
| 6 | Орлогын тайланд хүлээн зөвшөөрөгдөөгүй олз, гарз | - | - | - | - | - |
| 7 | Тайлант үеийн үр дүн | - | - | - | - | - |
| 8 | 2025 оны 12-р сарын 31-ний үдэгдэл | - | - | **4,744,206,409.50** | - | **4,744,206,409.50** |
| 8 | 2026 оны 1-р сарын 1-ний үдэгдэл | - | - | **4,744,206,409.50** | - | **4,744,206,409.50** |
| 9 | Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт | - | - | - | - | - |
| 10 | Дахин илэрхийлсэн үлдэгдэл | - | - | 4,744,206,409.50 | - | 4,744,206,409.50 |
| 12 | Үндсэн хөрөнгийн өсөлт бууралт | - | - | - | - | - |
| 11 | Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт бууралт | - | - | - | - | - |
| 13 | Орлогын тайланд хүлээн зөвшөөрөгдөөгүй олз, гарз | - | - | - | - | - |
| 14 | Гадаад валютын хөрвүүлэлтийн зөрүү | - | - | - | - | - |
| 15 | Тайлант үеийн үр дүн | - | - | **-442,579,342.00** | - | **-442,579,342.00** |
| 16 | 2025 оны 12-р сарын 31-ний үдэгдэл | - | - | **4,301,627,067.50** | - | **4,301,627,067.50** |

## 2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

| **Хөтөлбөр, төслийн ангилал** | | **Батлагдсан төсөв** | **Гүйцэтгэл** | **ЗӨРҮҮ** | |
|---|---|---|---|---|---|
| Код | **Үзүүлэлт** | | | **Зөрүү** | **Хувь** |
| 11 | НЭГ. ХӨДӨЛМӨР ЭРХЛЭЛТИЙГ ДЭМЖИХ САНГИЙН ОРЛОГО | 1,760,423,800.00 | 1,513,657,867.00 | 246,765,933.00 | 86% |
| 113 | ХБИ ажиллуулаагүйн төлбөрийн орлого | 3,300,000.00 | 5,707,430.00 | (2,407,430.00) | 173% |
| 117 | ХЭД сангаас хуваарилсан санхүүжилт | 1,057,123,800.00 | 810,357,867.00 | 246,765,933.00 | 77% |
| 119 | Санхүүгийн дэмжлэгийн эргэн төлөлт | 700,000,000.00 | 697,592,570.00 | 2,407,430.00 | 100% |
| | **НИЙТ ЗАРДЛЫН ДҮН** | **1,760,423,800.00** | **1,513,657,867.00** | | |
| **2** | **ХОЁР. ХӨДӨЛМӨР ЭРХЛЭЛТИЙН НИЙТЛЭГ ҮЙЛЧИЛГЭЭГ ХЭРЭГЖҮҮЛЭХ** | **84,664,800.00** | **38,278,148.00** | **46,386,652.00** | **45%** |
| 2 | ЗАРЦУУЛАЛТЫН ДҮН | 84,664,800.00 | 38,278,148.00 | 46,386,652.00 | 45% |

| | | | | | |
|---|---|---|---|---|---|
| **21** | **2.1 Ажил, мэргэжлийн чиг баримжаа олгох, зөвлөгөө өгөх үйлчилгээ** | **23,625,360.00** | **9,456,648.00** | **14,168,712.00** | **40%** |
| 211 | Ганцаарчилсан ажил, мэргэжлийн чиг баримжаа олгох, зөвлөгөө өгөх үйлчилгээ | 10,121,760.00 | 7,026,000.00 | 3,095,760.00 | 69% |
| 212 | Бүлгээр ажил, мэргэжлийн чиг баримжаа олгох, зөвлөгөө өгөх үйлчилгээ | 13,503,600.00 | 2,430,648.00 | 11,072,952.00 | 18% |
| **22** | **2.2 Ажилд зуучлах үйлчилгээ** | **61,039,440.00** | **28,821,500.00** | **32,217,940.00** | **47%** |
| 221 | Ажилд зуучлах үйлчилгээ | 52,169,040.00 | 26,246,500.00 | 25,922,540.00 | 50% |
| 222 | Хөдөлмөр эрхлэх чадавхийн үнэлгээ /профайлинг/ | 5,702,400.00 | 2,575,000.00 | 3,127,400.00 | 45% |
| 224 | Хөдөлмөр эрхлэх хувийн төлөвлөгөө боловсруулах | 3,168,000.00 | - | 3,168,000.00 | 0% |
| **31** | **3.1 Хөдөлмөрт бэлтгэх сургалт** | **33,450,000.00** | **27,150,000.00** | **6,300,000.00** | **81%** |
| 311 | Суурь ур чадварын сургалт | 11,250,000.00 | 11,250,000.00 | - | 100% |
| 3111 | Суурь ур чадварын сургалт зохион байгуулах | 11,250,000.00 | 11,250,000.00 | - | 100% |
| 312 | Танхимын болон үйлдвэрлэл дээрх мэргэжлийн сургалт | 6,300,000.00 | - | 6,300,000.00 | 0% |
| 3123 | Хоол унааны зардал | 6,300,000.00 | - | 6,300,000.00 | 0% |
| 313 | Аж ахуй эрхлэлтийн сургалт | 15,900,000.00 | 15,900,000.00 | - | 100% |
| 3131 | Аж ахуй эрхлэлтийн сургалт зохион байгуулах / жижиг зээл, санхүүгийн дэмжлэг олгохоос өмнөх сургалт/ | 3,000,000.00 | 3,000,000.00 | - | 100% |
| 3132 | Аж ахуй эрхлэлтийн сургалт зохион байгуулах / жижиг зээл, санхүүгийн дэмжлэг олгосны дараах сургалт/ | 4,500,000.00 | 4,500,000.00 | - | 100% |
| 3133 | Мал маллах болон малын ашиг шим боловсруулах сургалт зохион байгуулах | 8,400,000.00 | 8,400,000.00 | - | 100% |
| **32** | **3.2 Аж ахуй эрхлэлтийг дэмжих санхүүгийн дэмжлэг** | **1,188,240,000.00** | **1,143,658,000.00** | **44,582,000.00** | **96%** |
| 321 | Иргэн, аж ахуйн нэгжид санхүүгийн дэмжлэг олгох | 450,000,000.00 | 450,000,000.00 | - | 100% |
| 3211 | Иргэнд санхүүгийн дэмжлэг олгох | 450,000,000.00 | 450,000,000.00 | - | 100% |
| 322 | Малчдыг малжуулах | 320,000,000.00 | 320,000,000.00 | - | 100% |
| 3221 | Малгүй болон цөөн малтай малчин өрхийг малжуулах санхүүгийн дэмжлэг олгох | 320,000,000.00 | 320,000,000.00 | - | 100% |
| 323 | Шилдэг Старт-Ап залуучуудад санхүүгийн дэмжлэг олгох | 38,000,000.00 | 38,000,000.00 | - | 100% |
| 3231 | Шилдэг Старт-Ап залуу, залуучуудын багт санхүүгийн дэмжлэг олгох | 30,000,000.00 | 30,000,000.00 | - | 100% |
| 3232 | Старт-Ап залуучуудад гарааны бизнесийн дэмжлэг үзүүлэх /Сургалт, зөвлөгөө, ментор/ | 8,000,000.00 | 8,000,000.00 | - | 100% |
| 324 | Ахмадын санхүүгийн дэмжлэг | 300,000,000.00 | 300,000,000.00 | - | 100% |
| 3241 | Санхүүгийн дэмжлэг олгох | 300,000,000.00 | 300,000,000.00 | - | 100% |
| 325 | Ажил олгогчийг дэмжих | 55,440,000.00 | 15,840,000.00 | 39,600,000.00 | 29% |
| 3251 | Ажил олгогчид урамшуулал олгох /6 сараас дээш хугацаагаар бүртгэлтэй ажилгүй иргэнийг ажлын байраар хангасан/ | 39,600,000.00 | 15,840,000.00 | 23,760,000.00 | 40% |

| | | | | | |
|---|---|---|---|---|---|
| 3252 | Ажил олгогчид санхүүгийн дэмжлэг олгох /асрамжийн газраас гарсан, хорих ангиас суллагдсан иргэнийг ажлын байраар хангасан/ | 15,840,000.00 | - | 15,840,000.00 | 0% |
| 326 | Түрээсийн дэмжлэг үзүүлэх арга хэмжээ | 24,800,000.00 | 19,818,000.00 | 4,982,000.00 | 80% |
| 3261 | Түрээсийн төлбөрийн хөнгөлөлт үзүүлэх | 4,800,000.00 | 2,400,000.00 | 2,400,000.00 | 50% |
| 3262 | Борлуулалтын дэмжлэг үзүүлэх | 20,000,000.00 | 17,418,000.00 | 2,582,000.00 | 87% |
| **33** | **3.3 Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн хөдөлмөр эрхлэлтийг дэмжих хөтөлбөр** | **217,264,000.00** | **168,920,000.00** | **48,344,000.00** | **78%** |
| 332 | Санхүүгийн дэмжлэг | 201,820,000.00 | 166,820,000.00 | 35,000,000.00 | 83% |
| 3321 | Иргэнд санхүүгийн дэмжлэг олгох /50 хувь эргэн төлөлттэй/ | 200,000,000.00 | 165,000,000.00 | 35,000,000.00 | 83% |
| 3325 | Аж ахуй эрхлэлтийн сургалт зохион байгуулах /жижиг зээл, санхүүгийн дэмжлэг олгохоос өмнөх сургалт/ | 780,000.00 | 780,000.00 | - | 100% |
| 3326 | Аж ахуй эрхлэлтийн сургалт зохион байгуулах /жижиг зээл, санхүүгийн дэмжлэг олгохоос дараах сургалт/ | 1,040,000.00 | 1,040,000.00 | - | 100% |
| 333 | Борлуулалтын болон ажлын байрны түрээсийн төлбөрт дэмжлэг үзүүлэх | 2,400,000.00 | 2,100,000.00 | 300,000.00 | 88% |
| 3332 | Түрээсийн төлбөрийн хөнгөлөлт үзүүлэх | 2,400,000.00 | 2,100,000.00 | 300,000.00 | 88% |
| 334 | Хөгжлийн бэрхшээлтэй хүнд ажлын байр бий болгосон ажил олгогчид дэмжлэг үзүүлэх | 7,920,000.00 | - | 7,920,000.00 | 0% |
| 3341 | Ажил олгогчид урамшуулал олгох /ХБИ-ийг ажилд авч 12 сараас доошгүй хугацаагаар ажлын байраар хангасан ажил олгогч/ | 7,920,000.00 | - | 7,920,000.00 | 0% |
| 335 | Хөдөлмөр эрхлэлтийн сургалт зохион байгуулах | 5,124,000.00 | - | 5,124,000.00 | 0% |
| 3351 | Чадамжид суурилсан мэргэжлийн сургалт | 3,444,000.00 | - | 3,444,000.00 | 0% |
| 3353 | Хоол, унааны зардал | 1,680,000.00 | - | 1,680,000.00 | 0% |
| **34** | **3.4 Түр ажлын байрыг дэмжих арга хэмжээ** | **159,280,000.00** | **78,950,000.00** | **80,330,000.00** | **50%** |
| 341 | Мод тарих | 38,400,000.00 | 19,862,000.00 | 18,538,000.00 | 52% |
| 343 | Ахмад мэргэжилтний зөвлөх үйлчилгээ | 115,600,000.00 | 55,440,000.00 | 60,160,000.00 | 48% |
| 3431 | Ахмад мэргэжилтний зөвлөх үйлчилгээ зохион байгуулах | 75,600,000.00 | 55,440,000.00 | 20,160,000.00 | 73% |
| 3432 | Ахмадын төрийн бус байгууллагын зөвлөх үйлчилгээ | 40,000,000.00 | - | 40,000,000.00 | 0% |
| 344 | Хүүхэд хамгаалагч үйлчилгээ | 5,280,000.00 | 3,648,000.00 | 1,632,000.00 | 69% |
| **35** | **3.5 Засгийн газар, ХЭҮЗ-ийн шийдвэрээр тодорхойлогдсон хөтөлбөр, төсөл** | **13,500,000.00** | **10,080,000.00** | **3,420,000.00** | **75%** |
| 351 | Засгийн газраас болон ХЭҮЗ-ийн шийдвэрээр батлан хэрэгжүүлэх хөтөлбөр, арга хэмжээ | 13,500,000.00 | 10,080,000.00 | 3,420,000.00 | 75% |
| 3513 | Мэргэжлийн боловсрол, сургалтын байгууллагын суралцагчдыг ажил олгогчид дагалдуулан суралцуулахад дэмжлэг үзүүлэх | 3,500,000.00 | - | 3,500,000.00 | 0% |

| | | | | | |
|---|---|---|---|---|---|
| 3514 | Хөдөлмөрийн харилцааны хөтөлбөр | 10,000,000.00 | 10,080,000.00 | (80,000.00) | 101% |
| **4** | **ДӨРӨВ. ХӨДӨЛМӨР ЭРХЛЭЛТИЙГ ДЭМЖИХ ҮЙЛ АЖИЛЛАГАА** | **61,525,000.00** | **46,325,219.00** | **15,199,781.00** | **75%** |
| 403 | Хөдөлмөр эрхлэлтийн бүртгэл, мэдээллийн нэгдсэн сан үүсгэх, мэдээллийн системийг сайжруулах, шинэчлэх | 2,525,000.00 | 2,525,000.00 | - | 100% |
| 404 | Хөдөлмөр эрхлэлтийн байгууллага, ажилтнуудын чадавхи бэхжүүлэх сургалт, зөвлөгөөн зохион байгуулах | 19,000,000.00 | 13,999,969.00 | 5,000,031.00 | 74% |
| 405 | Хөдөлмөр эрхлэлтийг сурталчлах, олон нийтийг соён гэгээрүүлэх арга хэмжээ, хөдөлмөрийн яармаг, өдөрлөг зохион байгуулах, хууль тогтоомж, эрх зүйн актын уулзалт, хэлэлцүүлэг, зөвлөлгөөн | 8,000,000.00 | 6,225,250.00 | 1,774,750.00 | 78% |
| 406 | Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих үйл ажиллагаа, хөтөлбөрүүдийн хэрэгжилтэд дүн шинжилгээ, хяналт, үнэлгээ хийлгэх | 20,000,000.00 | 13,575,000.00 | 6,425,000.00 | 68% |
| 408 | Гарын авлага, маягт, хэвлэмэл материалын эх бэлтгэх, хэвлүүлэх | 12,000,000.00 | 10,000,000.00 | 2,000,000.00 | 83% |
| **411** | **Хөдөлмөр эрхлэлтийн үндэсний зөвлөл, аймаг, нийслэл, дүүргийн зөвлөлийн үйл ажиллагааг дэмжих** | **2,500,000.00** | **296,500.00** | **2,203,500.00** | **12%** |

## 3. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА

### 3.1 Байгууллага, түүний үйл ажиллагаа

Увс аймгийн Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний газрын эрхэм зорилго: "Хөдөлмөрийн зах зээлийн эрэлт нийлүүлэлтэд суурилсан нийгэм, эдийн засгийн өөрчлөлт хүн амын бүлгийн хэрэгцээнд тулгуурлан, цахим технологийг нэвтрүүлэх, хөдөлмөр эрхлэлт, нийгмийн халамжийн үйлчилгээг орон нутгийн онцлогт нийцүүлэн хэрэгжүүлж, иргэдийн амьдралын чанарыг дээшлүүлэхэд оршино.

### 3.2 Байгууллагын гадаад, дотоод орчин

Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сангийн удирдлага төсвийн шууд захирагчийн хувьд дараах хууль болон УСНББОУС, түүнд нийцүүлэн баталсан төсвийн байгууллагын Нягтлан бодох бүртгэлийн бодлого, журмын хүрээнд төсөв, санхүү, нягтлан бодох бүртгэлийн үйл ажиллагааг явуулж байна. Үүнд:

- Төсвийн тухай хууль
- Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хууль
- Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль
- Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хууль
- Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хууль
- худалдан авах тухай хууль
- Шилэн дансны тухай хууль

Тайлант хугацаанд байгууллагын үйл ажиллагаа, санхүү, нягтлан бодох бүртгэлд мөрддөг хууль тогтоомж болон бодлого чиглэлд өөрчлөлт ороогүй.

Байгууллагын удирдлагын хэрэгжүүлж буй дотоод хяналтаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил гүйцэтгэсний

үр дүнд дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалт, хэрэгжилт үр нөлөөтэй байна. Төсвийн ерөнхийлөн захирагчаас эрсдэлд суурилсан дотоод аудит хийгээгүй байна.

### 3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сангийн 2025 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккруэль сууриар хөтөлсөн байна.

Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг Сангийн яамнаас авч хэрэгжүүлж байгаа нягтлан бодох бүртгэлийн бодлогын шинэчлэлт, холбогдох стандарт, хууль тогтоомжтой нийцтэй байгаа эсэхийг судалж үзэхэд шинээр батлагдсан бодлого, журамд нийцсэн байна.

Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сангийн санхүүгийн тайланг бэлтгэхдээ нягтлан бодох бүртгэлийн “Axplorer” программ хангамж ашигладаг байна.

Тус байгууллагын мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь холбогдох хууль тогтоомж, нягтлан бодох бүртгэлийн стандартад нийцсэн, тус байгууллагын үйл ажиллагааны онцлогт тохирсон байна.

### 3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого, толилуулгад гарсан өөрчлөлтүүд

Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сангийн 2025 оны санхүүгийн тайланг Сангийн сайдын 2025 оны А/3 тушаалаар баталсан "Төсвийн байгууллагын дагаж мөрдөх нягтлан бодох бүртгэлийн журам"-ын дагуу бэлтгэсэн байна.

Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сангийн 2025 оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 374,748.1 мянган төгрөгөөр буюу 8.5 хувиар буурсан байна.

*Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт*

/мянган төгрөгөөр/

| Үзүүлэлт | Эхний үлдэгдэл | Эцсийн үлдэгдэл | Өөрчлөлт |
|---|---|---|---|
| Б | 1 | 2 | 3=2-1 |
| Мөнгөн хөрөнгө | 0.0 | 0.0 | 0.0 |
| Авлага | 4,744,386.4 | 4,369,638.3 | 374,748.1 |
| Бараа материал | 0 | 0 | 0 |
| Үндсэн хөрөнгө | 0 | 0 | 0 |
| **Нийт хөрөнгө** | 4,744,386.4 | 4,369,638.3 | 374,748.12 |
| Өр төлбөр | 180.0 | 68,011.2 | 67,831.2 |
| Засгийн газрын хувь оролцоо /Эздийн өмч/ | 4,744,386.4 | 4,369,638.3 | (374,748.1) |
| **Өр төлбөр ба цэвэр хөрөнгө/өмчийн дүн** | 4,744,386.4 | 4,369,638.3 | (374,748.1) |

### 3.5 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь тус хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

### 3.5.1 Төсвийн төлөвлөлт

Тус сангийн 2025 оны төсвийн төсөлд зардлыг санхүүжүүлэх эх үүсвэрийг 3,288,288.0 мянга, зарлагыг 3,288,288.0 мянган төгрөгөөр тооцон төлөвлөж дээд шатны төсвийн захирагчид хүргүүлсэн байна.

Төсвийн захирагчийн хүргүүлсэн төсвийн төслөөс 1,527,865.0 мянган төгрөгөөр буурч 1,760,423.0 мянган төгрөгөөр баталсан байна. Энэ нь хөдөлмөр эрхлэлтийн үндэсний зөвлөлийн баталсан хөтөлбөрт өөрчлөлт орсонтой холбоотой байна.

### 3.5.2 Төсвийн гүйцэтгэл

Тайлант онд төсвийн захирагчийн хэрэгжүүлэх санхүүжилт 1,760,423.0 мянган төгрөгийн төсөв баталжээ.

Гүйцэтгэлээр улсын төсвөөс 1,760,423.0 мянган төгрөгийн санхүүжилт олгосон байна.

Гүйцэтгэлээр Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих төв сангаас 1,760,423.0 мянган төгрөгийн санхүүжилт хүлээн авч 1,513,657.8 мянган төгрөгийн зарлага гарч хөтөлбөрийн санхүүгийн дэмжлэгийн эргэн төлөлтийн орлогоос 1,542,328.0 мянган төгрөг, хөгжлийн бэрхшээлтэй иргэн ажиллуулаагүйн төлбөрийн орлогоос 5,707.4 мянган төгрөг, нийт 1,548,035.5 мянган төгрөгийн орлого орсон. Санхүүжилтийн үлдэгдэл болон эргэн төлөлт 1,076,501.4 мянган төгрөгийг хөдөлмөр эрхлэлтийг дэмжих санд татан төвлөрүүлсэн байна.

### 3.5.3 Нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т “нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна” гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

Нэмэлт санхүүжилтийн дансанд орлого зарлага хийгдээгүй болно.

Нэмэлт төсвийн тайланг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.6-д харуулав.

### 3.5.4 Төсөл хөтөлбөрийн үе шат, хүрэх үр дүн

Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих санд тайлант хугацаанд 5 хөтөлбөр 2 үйлчилгээг хэрэгжүүлсэн байна. Хэрэгжилтийг хүснэгт 2-т дэлгэрэнгүй харуулав.

*Хүснэгт 2. Хөтөлбөр, арга хэмжээний төлөвлөгөө, гүйцэтгэл*

/мянган төгрөгөөр/

| № | Хөтөлбөр арга хэмжээ | Төлөвлөгөө | Гүйцэтгэл | Зөрүү | Хувь |
|---|---|---|---|---|---|
| 1 | Хөдөлмөр эрхлэлтийн нийтлэг үйлчилгээ | 88,377.6 | 38,278.00 | 50,099.00 | 43.3 |
| 2 | Хөдөлмөрт бэлтгэх хөтөлбөр | 33,450.00 | 27,150.00 | 6,300.00 | 81.1 |
| 3 | Аж ахуй эрхлэгчдийг дэмжих хөтөлбөр | 1,189,440.00 | 1,143,658.00 | 45,782.00 | 96 |
| 4 | Хөгжлийн бэрхшээлтэй иргэний хөдөлмөр эрхлэлтийг дэмжих хөтөлбөр | 217,264.00 | 168,920.00 | 48,344.00 | 77.7 |
| 5 | Түр ажлын байрыг дэмжих хөтөлбөр | 159,280.00 | 78,950.00 | 80,330.00 | 49.5 |
| 6 | Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих үйл ажиллагаа | 64,025.00 | 46,325.1 | 17,699.7 | 72.3 |
| 7 | Аймгийн хөдөлмөр эрхлэлтийн салбар зөвлөлийн зардал | 2,500.00 | 296.5 | 2,203.5 | 11.8 |

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.5-д харуулав.

### 3.5.4 Худалдан авах ажиллагааны гүйцэтгэл

Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих санд аймгийн Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих чиглэлээр үйл ажиллагаа явуулж, бараа бүтээгдэхүүнтэй холбоотой худалдан авалт хийгдээгүй байна.

## 4. АУДИТЫН ТАЙЛАН

### 4.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана” гэж заасны дагуу Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сангийн 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд аудит хийгдэх байгууллага, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, санхүүгийн тайлагналын үзэл баримтлал, аудитаар илрүүлсэн буруу илэрхийлэл, түүнийг шийдвэрлэсэн байдал, дараагийн аудитаар анхаарах асуудал болон аудиторын дүгнэлт, дүгнэлтийн үндэслэлийг хураангуйлан толилуулав. Мөн байгууллагын үйл ажиллагааг сайжруулахад чиглэсэн зөвлөмж өгөөгүй болно.

Аудитыг Увс аймаг дахь Төрийн аудитын газрын аудитор Л.Шагдарсүрэн гүйцэтгэж, хяналтыг аудитын менежер М.Бат-Амгалан, дарга, тэргүүлэх аудитор М.Батсуурь нар тус тус хэрэгжүүлсэн.

Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сангийн 2026 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Увс аймаг дахь Төрийн аудитын газарт 2026 оны 02 дугээр сарын 25-ны өдрийн 152 дугаар албан бичгээр ирүүлсэн.

### 4.2 Материаллаг байдал

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр нийт зардлыг сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэлийг “Дунд” гэж үнэллээ.
Төлөвлөлтийн материаллаг байдлыг 2024 оны Санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардлыг 1,853,570.0 мянган төгрөгийн 1.0 хувиар буюу 18,535.7 мянган төгрөгөөс 80 хувиар тооцож 14,828.5 мянган төгрөгөөр тогтоосныг аудитын явцад дахин хянаж шинэчлэн тогтоох шаардлагатай гэж үзсэн.
Гүйцэтгэлийн шатанд материаллаг байдлыг 2025 оны санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардал 1,490,410.6 мянган төгрөгийн 1.0 хувиар буюу 1,490,410.6 мянган төгрөгөөс 80 хувиар тооцож 11,928.5 мянган төгрөгөөр тогтоосон.

### 4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт

Төрийн хэмнэлтийн тухай хууль хэрэгжиж эхэлсэнтэй холбоотойгоор Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сангийн тухайн хуульд хамаарах зүйл заалтын хүрээнд горим сорил хэрэгжүүлсэн. Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилттэй холбоотой зөрчил гараагүй болно.

### 4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын

талаарх дүгнэлтийг санхүүгийн тайланд өгөх аудиторын дүгнэлтээс тусад нь салгах хэрэгтэй гэж заасан байна.

#### 4.4.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан "Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам"-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор www.shilendans.gov.mn цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Тайлант хугацаанд www.shilendans.gov.mn цахим хуудсанд оруулбал зохих 1,064,780.0 мяган төгрөгийн үнийн дүн бүхий 157 мэдээллийг олон нийтэд мэдээлсэнээс 63,600.0 мянган төгрөгийн 10 мэдээллийг хугацаа хоцроож мэдээлсэн байна.

Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим сорилд үндэслэн шилэн дансанд байршуулсан мэдээлэл нь шилэн дансны тухай хууль тогтоомжийн холбогдох заалттай нийцсэн гэж дүгнэлээ.

#### 4.4.2 Бусад хууль тогтоомжийн хүрээнд

Төрийн аудитын байгууллагаас 2025-2026 онд гүйцэтгэх санхүүгийн тайлангийн аудитаар баримтлах ерөнхий чиглэлд тусгагдсан болон бусад хууль тогтоомжтой холбоотой хэрэгжүүлсэн горим сорилын хүрээнд зөрчил илрээгүй болно.

### 4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

#### 4.5.1 Завсрын аудитын талаар

Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сангийн 2025 оны санхүүгийн тайланд завсрын аудит хийгдээгүй болно.

#### 4.5.2 Өмнөх аудитын мөрөөр авч хэрэгжүүлсэн арга хэмжээний үр дүн

Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сангийн 2025 оны санхүүгийн тайлангийн аудитаар акт, албан шаардлага, зөвлөмж өгөөгүй байна.

### 4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал

Дараагийн аудитаар анхаарах асуудал байхгүй байна.

## 5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

Аудитаар зөрчил илрээгүй болно.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

## 6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ

### Санхүүгийн тайлангийн аудитын алдааны нэгтгэл

/мянган төгрөгөөр/

| Алдааны товч утга | Нийт алдаа | | Мэдээллийг тусгахгүй орхигдуулсан | | Буруу тусган илэрхийлсэн | | Үүнээс | | | | Зөвлөмж | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | Залруулсан | | Залруулаагүй | | | |
| | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн |
| | | | | | | | | | | | | |
| | | | | | | | | | | | | |
| Дүн | | | | | | | | | | | | |

### Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл

/мянган төгрөгөөр/

| Зөрчлийн товч утга | Нийт зөрчил | | Үүнээс | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | Төлбөрийн акт | | Албан шаардлага | | Зөвлөмж | | Хариуцлага тооцуулах албан шаардлага | | Хууль, хяналтын байгууллагад шилжүүлсэн асуудал | |
| | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Албан тушаалтны тоо | Тоо | Дүн |
| | | | | | | | | | | | | |
| | | | | | | | | | | | | |
| Дүн | | | | | | | | | | | | |

### Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

/мянган төгрөгөөр/

| Зөрчлийн товч утга | Нийт зөрчил | | Үүнээс | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | Төлбөрийн акт | | Албан шаардлага | | Зөвлөмж | |
| | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн |
| Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилттэй холбоотой зөрчил | | | | | | | | |
| | | | | | | | | |
| | | | | | | | | |
| Дүн | | | | | | | | |
| Бусад хууль тогтоомжтой холбоотой зөрчил | | | | | | | | |
| | | | | | | | | |
| | | | | | | | | |
| Дүн | | | | | | | | |
| Нийт дүн | | | | | | | | |

АУДИТЫН ТАЙЛАНГ

ХЯНАСАН: ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР /М.БАТСУУРЬ/

АУДИТЫН МЕНЕЖЕР /М.БАТ-АМГАЛАН/

БЭЛТГЭСЭН: АУДИТОР /Л.ШАГДАРСҮРЭН/

2026 оны 03 дугаар сарын 12-ны өдөр